

МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ХАМТАРСАН ХИЛ ДАМНАСАН ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ, БОЛОМЖ

Н.Отгонсайхан

Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургууль,
E-mail хаяг: otgonsaikhan@num.edu.mn

Хураангуй. Далайд гарцгүй, өргөн уудам газар нутагтай Монгол Улсын хувьд хөрш орнуудтай хилийн боомтыг өргөжүүлэх замаар худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах нь хилийн аюулгүй байдлыг хангах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, худалдааг өргөжүүлэх нэг гол шийдэл байж болох юм. Монгол Улс БНХАУ-тай хил дамнасан чөлөөт бүсийг байгуулах асуудалд сүүлийн жилүүдэд онцгойлон анхаарч, энэ чиглэлийн яриа хэлэлцээг төр засгийн төвшинд хийгээд байгаа билээ. Иймд Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан нөхцөл, боломжийн талаар судлахыг зорилоо. Энэхүү ажил нь үндсэн 4 хэсгээс бүрдэх ба I хэсэгт Монгол Улс, БНХАУ-ын хооронд хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлаар хийгдсэн хэлэлцээ, II хэсэгт хил дамнасан чөлөөт бүс ба Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, III хэсэгт Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдаа, төгсгөлд нь БНХАУ-тай хил дамнасан чөлөөт бүс байгуулах боломжийн талаар тусгасан болно.



Түлхүүр үг. Гадаад худалдаа, экспорт, импорт, хил дамнасан чөлөөт бүс, стратегийн түншлэл

I. Монгол Улс, БНХАУ-ын хооронд хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлаар хийгдсэн яриа хэлэлцээ

Хил дамнасан чөлөөт бүс байгуулах замаар худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудал нь улс орнуудын Засгийн газрын түвшинд хийгдсэн яриа хэлэлцээнээс шууд шалтгаалдаг. Хоёр орны төр засгийн албан ёсны айлчлал, уулзалтын үеэр хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудалд ихээхэн ач холбогдол өгч, холбогдох бичиг баримтуудад тусгалаа олсон нь хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны чухал хэсэг болоод байна.

2013 онд Монгол Улсын Ерөнхий сайдын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр тал “Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулсан билээ. Энэхүү хөтөлбөрт “Талууд хоёр улсын хамтын ажиллагааны тодорхой суурь нөхцөл бүрдсэн хил орчмын бүс нутагт хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах боломжийг идэвхтэй эрэлхийлнэ” гэж тусгасан нь хоёр орны бизнес эрхлэгчид болон судлаачдын анхаарлыг татаж эхэлсэн.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 оны 8 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр хоёр орны төрийн тэргүүн “Иж бүрэн стратегийн түншлэлийн хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурсан.¹ Энэхүү тунхаглалын хоёр дах

¹ Энэхүү тунхаглалын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэсэгт талууд хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх арга хэмжээ авах, Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ боомтыг олон улсын чанартай болгох, Баянхошуу-Өвдөг,

хэсэгт “Талууд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нөөц боломжийг ашиглан, худалдааг хөнгөвчлөх бодлогыг дэмжих, Зүүн Хойд Азийн үзэсгэлэн яармаг, Монгол, Хятад, Оросын худалдаа, эдийн засгийн чуулга уулзалт, Монгол, Хятадын үзэсгэлэн яармаг зохион байгуулах зэрэг замаар хоёр улсын худалдааны хэмжээг жилээс жилд нэмэгдүүлэх, 2020 он гэхэд 10 тэрбум ам.долларт хүргэхийг зорино. Талууд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хоёр талын худалдаан дахь хувийг нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжинэ” гэж тусгасан.

Энэ ажлын хүрээнд Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах тухай Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, Монгол Улсын Замын-Үүд гэх мэт нөхцөл бүрдүүлсэн бүсэд хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулахыг судлахаар тохиролцжээ.

Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор 2015 оны 3 дугаар сард Монгол Улсын аж үйлдвэрийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын Худалдааны яамны Гадаадын хөрөнгө оруулалтын газрын дэд дарга тэргүүтэй төлөөлөгчидтэй хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудлыг судлах хоёр талын ажлын хэсгийн анхны зөвлөлдөх уулзалтыг ӨМӨЗО-ны Эрээн хотод хийж, талууд хоёр улсын хооронд хил дамнасан чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын асуудлаар холбогдох ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх хугацааг тохирон нэгдсэн ойлголтонд хүрсэн аж.

Энэ уулзалтаас хойш Эрээн – Замын-Үүдийн хил дамнасан чөлөөт бүсийг хөгжүүлэхэд ӨМӨЗО ихээхэн анхаарал хандуулж эхэлсэн. Монгол Улсын талаас Хятадын талын хөрөнгө оруулагчдад Замын-Үүд чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор хэд

Бургастай-Лаомяо, Ханги-Мандал, Хавирга-Архашаат боомтуудыг байнгын ажиллагаатай болгох ажлыг идэвхтэй урагшлуулах, Цагаандэл Уул-Өлзийт боомтыг нээх ажлыг түргэтгэхээр заажээ.

хэдэн удаагийн уулзалтыг зохион байгуулсан ба Монгол Улсын аж үйлдвэрийн дэд сайд 2015 оны 6 дугаар сард ӨМӨЗО-ны Худалдааны танхимийн дарга тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзах үеэр Хятадын тал бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлнэ гэдгийг албан ёсоор хэлжээ.

2016 оны 5 дугаар сард Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын XIV хуралдааны үеэр Хятад Улсын Худалдааны Яам, Монгол Улсын Аж Үйлдвэрийн Яам Замын-Үүд – Эрээн боомтод хил дамнасан эдийн засгийн бүс байгуулах асуудлаар хамтран ажиллах ерөнхий төлөвлөгөөнд гарын үсэг зурснаар бүсийн зорилго, зарчим, механизм тодорхой болсон нь чухал алхам болсон. Гэтэл албан ёсны төлөвлөгөөний дагуу Хятадын тал шаардлагатай гэрээ, хэлэлцээрийн төслийг Монголын талд хүргүүлсэн боловч Монголын тал хариу өгөөгүйн улмаас хилийн хамтын ажиллагааны бүс байгуулах төсөл 2017 оныг дуустал гацаанд оржээ².

Улмаар 2018 оны 4 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр Замын-Үүд, Эрээний³ түшиглэсэн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах хэлэлцээг түргэтгэх тухай санамж бичиг байгуулсны дагуу Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах бэлтгэл үйл явц эрчимжиж эхэлсэн.

2018 оны 9 дүгээр сард Бээжин хотод болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын XV хуралдааны үеэр

² Шадар сайдын Ажлын албаны мэдээлэл <http://www.olloo.mn/n/49382.html>

³ Эрээний чөлөөт бүсийн төвийн хэсэгт газар дор дэд бүтцийн сүлжээ байгуулах ажлыг 2017 оны хавар эхлүүлж, 2018 оны 9 сарын байдлаар дулаан, цахилгаан, холбоо, цэвэр, бохир усны шугамын орчин үеийн шийдэл бүхий цогц ажлыг гүйцэтгэсэн, ойрын хугацаанд 7 үйлдвэрийн барилгыг угсарч дуусгах, 2019 он гэхэд энэ хэсэгт 800 сая юань буюу 126 сая орчим ам.долларын өртөг бүхий ажил хийгдэх талаар Эрээн хотын удирдлага ярьжээ. Энэ төвд Монголын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид Хятадын холбогдох байгууллагууд хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрсөн бараа бүтээгдэхүүнээ худалдаалж эхэлжээ. Эндээс Хятадын иргэд өдөрт 8000 юань хүртэлх үнийн дүн бүхий барааг татваргүйгээр худалдан авч болдог.

хоёр улсын худалдааны эргэлтийг 2020 онд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг биелүүлэхийн тулд худалдааны бүтцийг шинэчлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэх саналыг манай талаас тавиад байна.

Ийнхүү төр засгийн хэмжээнд хил дамнасан чөлөөт бүсийг байгуулах асуудал яригдаж байгаа хэдий ч Монгол Улсын бэлэн байдал чухал. Иймээс дараагийн хэсэгт энэ төрлийн чөлөөт бүс байгуулах эрхзүйн орчин болон дэд бүтцийн асуудал бэлэн болсон эсэхийг авч үзсэн болно.

II. Хил дамнасан чөлөөт бүс ба Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалыг Улсын Их Хурал 1995 онд баталж, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үндэслэл шаардлага, зарчим, угтвар нөхцөл, баримтлах шалгуурыг тодорхойлсон. Улмаар 2002 онд Чөлөөт бүсийн, 2002 онд “Алтанбулаг” худалдааны, 2003 онд “Замын-Үүд” эдийн засгийн болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд батлагдаж, эрх зүйн орчин бүрдээд 15 гаруй жил өнгөрч байгаа ч тодорхой үр дүнд хүрч чадаагүй.

Иймээс улс орны хөгжлийн өнөөгийн шаардлага, хэтийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч Чөлөөт бүсийн тухай хуулийг 2015 онд шинэчлэн найруулж, дээрх хуулиуд бүгд хүчингүй болсон.

Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар дараах зарчмын өөрчлөлтүүд гарчээ. Үүнд:

- Чөлөөт бүсийг хэлбэрээр нь ангилсан заалтыг өөрчилж эдийн засгийн чөлөөт бүс гэдэг нэг л статустай болгосон, чөлөөт бүсийг хилийн боомт болон Засгийн газрын санал болгосон

тусгай бүс нутагт байгуулж хөгжүүлэх, хил дамнасан чөлөөт бүсийн эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

- Чөлөөт бүсэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд үл харшлах, олон улсын гэрээний тулгуур зарчим, шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, худалдаа, олон улсын банк санхүү, даатгал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, нийгэм, зах зээл, дэд бүтцийн бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор тусгасан.
- Чөлөөт бүсийн удирдлага, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг хуульчилж, Чөлөөт бүсийн Захирагчийн эрх хэмжээг нэмэгдүүлэв. Чөлөөт бүсэд бүртгэлийн, үйлчилгээний бүх байгууллага нэг дор төвлөрсөн, захиргаатай, захиргаа нь босоо удирдлагатай, бүх үйлчилгээг нэг цонхны үйлчилгээгээр шуурхай үзүүлэх боломжийг нээсэн.
- Татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах зэрэг үйл ажиллагааны тусгай дэглэмийг хуульчилж өгөв.
- Концессын гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн хөрөнгөөр чөлөөт бүсийг бүхэлд нь буюу хэсэгчлэн байгуулж, хөгжүүлэх боломжтойгоор шинэчлэн тусгав.
- Чөлөөт бүсэд гадаад болон дотоодын иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмших, ашиглах зохицуулалтыг тодорхой болгов. Тухайлбал, чөлөөт бүсэд хөрөнгө оруулагч газрыг Монгол Улсын ямар хуулийн дагуу, хэдий хугацаанд, ямар төлбөртэй эзэмших, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлоход ямар хөнгөлөлт эдлэх зэрэг бүх зүйлийг хууль эрхзүйн талаас нь тодорхой болгожээ.

Хууль батлагдсанаар хил дамнасан байдлаар, хилийн боомтын бүсэд, Засгийн газрын санал болгосон тодорхой бүс нутгуудад чөлөөт бүс байгуулах эрхзүйн боломж бүрдсэн бөгөөд нэгдүгээрт Монгол Улсад, хоёрдугаарт хөрөнгө оруулагчдад, гуравдугаарт хөрш орон, бүс нутагт ашигтай байх бололцоог бүрдүүлсэн учраас чөлөөт бүс хөгжинө гэж хууль санаачлагчид үзжээ.

Уг хуульд “хил дамнасан чөлөөт бүс” гэж хил залгаа улсын хилийн боомтын газар нутагт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг хэлэхээр заажээ. Энэ хууль батлагдсанаар хөрш орнуудтай хил дамнасан чөлөөт бүс байгуулах тухай яриа хэлцэл эрчимтэй яригдаж эхэлсэн. Тухайлбал, БНХАУ-тай хамтарсан хил дамнасан чөлөөт бүсийг Замын-Үүдэд байгуулах тухай, Алтанбулагийн чөлөөт бүсэд Польш зэрэг Европын орнууд Оросыг дамнаж хөрөнгө оруулах тухай санал гэх мэт.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн дарга Сүхбаатар аймагт ажлын айлчлал хийж, хоёр аймгийн удирдлага “Тал нутгийн торгоны замын эдийн засгийн чөлөөт бүс” байгуулах хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зуржээ.

Мөн УИХ-аар 2013 онд баталсан “Хилийн боомтын тухай” хууль⁴ нь хил дамнасан чөлөөт бүс байгуулах чиглэлд гарсан чухал шинэчлэл болсон. Энэ хууль батлагдсанаар хилийн боомтын эрх зүйн зохицуулалт нэг мөр болох, боомтын хөгжлийг тусгайлан хариуцсан байгууллагын тогтолцоотой болох ач холбогдолтой аж.

Түүнчлэн бизнес эрхлэгчид энэхүү бүсэд үйлчлэх татварын тусгай дэглэмийг ихээхэн сонирхож байгаа бөгөөд Чөлөөт бүсийн тухай хуулиар дараах хөнгөлөлтүүд үйлчлэнэ. Үүнд:

- Хилийн чанадаас чөлөөт бүсэд импортлосон бараанд импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;

⁴ 2014 оны 4 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

- Барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй;
- Онцгой албан татвар ногдох бараа болон эм эмнэлгийн хэрэгслээс бусад зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөнө.
- Чөлөөт бүсэд инноваци, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг тодорхой хугацаанд орлогын албан татвараас чөлөөлнө.
- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөөс тодорхой хугацаанд чөлөөлөгдөнө.
- Чөлөөт бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжүүд оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдэлнэ.
- Үл хөдлөх хөрөнгийн орлогын албан татвараас бүрэн чөлөөлөгдөнө.
- Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй.

Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын тухай” хуулинд эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх тохиолдолд эхний 5 жил татвараас чөлөөлөхөөр тусгагдсан. Татварын энэхүү таатай нөхцөл хөрөнгө оруулагчдыг татах нэг гол хөшүүрэг болох юм.

Монгол Улсын олон улсын гэрээ болон Засгийн газрын тогтоолд зааснаар манай улсын БНХАУ-тай хиллэдэг хэсэгт 13 авто болон төмөр замын боомттой (Хүснэгт 1). Эдгээр боомтын тав нь олон улсын шинжтэй, тав нь хоёр талын, байнгын бусад нь хоёр талын, түр боомтууд.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Хүснэгт 1. Монгол Улсын хилийн боомт
(Монгол-Хятадын хил)

№	Боомтын нэр	Төрөл	Зэрэглэл	Горим	Тайлбар	Хилийн боомтод үйл ажиллагаа явуулах гаалийн байгууллага
1	Хавирга	Авто зам	хоёр талын	Байнга	Даваа-Ням	Дорнод аймаг дахь гаалийн газар
2	Баянхошуу	Авто зам	Хоёр талын	Байнга	“Петрочайна дачин тамсаг Монгол” ХХК-ийн газрын тосны ачаа тээвэр Бусад хөдөлгөөнүүдэд	
3	Сүмбэр	Авто зам	Олон улсын	Түр	Даваа-Баасанд заасан хугацаанд ажиллана	
4	Бичигт	Авто зам	Олон улсын	Байнга	“Петрочайна дачин тамсаг Монгол” ХХК-ийн газрын тосны ачаа тээвэр Бусад хөдөлгөөнүүдэд	Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар
5	Ханги	Авто зам	Хоёр талын	Байнга	Уул уурхай, эрчим хүчний ачаа тээвэр Бусад хөдөлгөөн	Сайншанд дахь гаалийн газар
6	Замын-Үүд	Төмөр зам	олон улсын	Байнга	24 цагаар ТЗ-ын хуваарийн дагуу ажиллана.	Замын-Үүд дэх гаалийн газар
7	Замын-Үүд	Авто зам	Олон улсын	Байнга	Даваа-Ням	

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

№	Боомтын нэр	Төрөл	Зэрэглэл	Горим	Тайлбар	Хилийн боомтод үйл ажиллагаа явуулах гаалийн байгууллага
8	Гашуун сухайт	Авто зам	Хоёр талын	Байнга	Нүүрс, зэсийн баяжмал, газрын тосны ачаа тээвэр Бусад хөдөлгөөн	Гашуунсухайт дахь гаалийн газар
9	Шивээхүрэн	Авто зам	Хоёр талын	Байнга	Нүүрс, зэсийн баяжмал, газрын тосны ачаа тээвэр Бусад хөдөлгөөн	Шивээхүрэн дэх гаалийн газар
10	Бургастай	Авто зам	Хоёр талын	Түр	Даваа-Баасанд заасан хугацаанд ажиллана	Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороо
11	Байтаг	Авто зам	Хоёр талын	Түр	5, 7, 9 сарын сүүлийн 15 хоногт ажиллана	Ховд аймгийн Булган дахь гаалийн газар
12	Булган	Авто зам	Олон улсын	Байнга	Даваа-Баасан	
13	Даян	Авто зам	Хоёр талын	Түр	Даваа-Нямд заасан хугацаанд ажиллана	Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар

Эх сурвалж: <http://customs.gov.mn/2018-12-18>

Орчин үед гадаад худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилттой уялдуулан хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын стандартын дагуу хөгжүүлэх асуудлыг нэгдсэн бодлоготойгоор зохион байгуулах шаардлага бидний өмнө зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү бодлогын нэг хэсэг нь хил дамнасан чөлөөт бүс байгуулах юм.

Хил дамнасан чөлөөт бүс байгуулахад хөрш орнууд хоорондын худалдааны нөхцөл байдал чухал үүрэг гүйцэтгэх учраас дараах

хэсэгт хоёр орны худалдааны өнөөгийн байдлыг авч үзэв.


III. Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдаа

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд гадаад худалдаа чухал байр суурь эзэлж, өргөжин тэлсээр байна. Зах зээлийн шилжилтийн эхэн үед гадаад худалдаа уналтад орж 1991 онд өмнөх онтой харьцуулахад 57 орчим хувиар буурч худалдааны эргэлт 708.9 сая ам.долларт хүрч байсан бол 1990-ээд оны дунд үеэс тогтвортой өссөн. 2000 онд худалдааны эргэлт анх удаа 1.0 тэрбум ам.долларт хүрснээс хойш дэлхийн эдийн засгийн хямралын үеийг эс тооцвол тасралтгүй өсч 2003 он гэхэд 1990 оны худалдааны эргэлтэд дөхөж очжээ. Үүнээс хойш 2011 онд экспорт 4817.5 сая ам.доллар, импорт 6598.4 сая ам.долларт хүрч, нийт бараа эргэлт өмнөх оноос 5307.3 сая ам.доллар буюу 86.9 хувиар, экспорт 1909.0 сая ам.доллар буюу 65.6 хувиар, импорт 3398.3 сая ам.доллараар буюу 2.1 дахин өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт (Зураг 1) юм.

Монгол Улс 2017 онд 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10538 сая ам.доллар, үүнээс экспорт 6201 сая ам.доллар, импорт 4337 сая ам.долларт хүрсэн нь нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2264 (27.4%) сая ам.доллар, үүнээс экспорт 1285 (26.1%) сая ам.доллараар, импорт 979 (29.2%) сая ам.доллараар тус тус өсжээ.

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

Зураг 1. Монгол Улсын гадаад худалдаа, сая ам.долл. (1990-2017)



Эх сурвалж: 1212.mn

Гадаад худалдааны тэнцэл 1994-1995 оны боловсруулах үйлдвэрийн сэргэлт, 2006 оны эдийн засгийн өсөлтийг дагуулсан экспортын барааны гадаад зах зээлийн үнийн өсөлтийн оргил үед ашигтай бусад онуудад алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ байнга өссөөр 2012 онд түүхэнд байгаагүй өндөр түвшинд буюу 2.4 тэрбум ам.доллар болж, өнгөрсөн оноос 32 хувиар, 2010 онтой харьцуулахад 8 дахин өсч байсан. Харин 2014 оноос эхлэн Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч эхэлсэн бөгөөд эрдэс бүтээгдэхүүн ялангуяа нүүрсний экспортын хэмжээ өссөнөөр энэ үзүүлэлт байнга сайжирч 2017 онд 1863 сая ам.долларт хүрч 2016 оноос 19.6 хувиар өссөн.


Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихээс өмнө хуучин социалист системийн орнуудтай ялангуяа ОХУ-тай худалдаа хийж байсан бол 1990 оноос огцом буурч БНХАУ-тай хийх худалдаа зонхилох болжээ.

Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газар 1990-ээд оны эхэн үед худалдааны шинэ хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоорондын худалдааны хэмжээг ихээхэн нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Тухайлбал,

Монгол Улсаас БНХАУ-тай хийсэн худалдаа 1990 онд 33.6 сая ам.доллар байсан бол 2017 оны байдлаар худалдааны нийт эргэлт 6.7 тэрбум ам.доллар болж, 200 дахин өссөн. Үүнээс экспорт 5.3 тэрбум ам.доллар, импорт 1.4 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 3.9 тэрбумын ашигтай гарсан. БНХАУ-тай хийж буй худалдааны тэнцэл байнга эерэг гардаг хэдий ч нийт экспортод түүхий эд, эрдэс бүтээгдэхүүн давамгайлж байгаа нь тийм ч сайн үзүүлэлт биш юм.

Монгол Улсын БНХАУ-тай хийж буй худалдааны (экспорт, импорт, нийт эргэлт) өөрчлөлтийг үнийн дүнгээр дараах (Зураг 2)-т үзүүлэв.

Зураг 2. Монгол Улсын БНХАУ-тай хийж буй худалдаа, сая ам.долл. (1990-2017)




Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд гол түнш орнууд болох БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ зэрэг улсууд 90 гаруй хувь, эдгээр орноос Хятад улс сүүлийн жилүүдэд дангаараа 60 гаруй хувийг эзэлж байгаа юм. 2017 оны эцсийн байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 63.8 хувь, экспортын 85.6 хувь, импортын 32.6 хувь (зураг 3) зөвхөн БНХАУ-д ногдож байгаа

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнансан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

нь манай улсын гадаад худалдаа БНХАУ-аас хэт их хамааралтай болсныг харуулж байна.

Зураг 3. Монгол Улсын гадаад худалдаанд
БНХАУ-ын эзлэх хувийн жин, 1990-2017



Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй барааны бүтцэд эрдэс болон малын гаралтай ноос, ноолуур, арьс шир гэсэн нэмүү өртөг шингээгүй түүхий эд зонхилох хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын нийт экспортын 80-90 орчим хувь, Хятадад хийж буй экспортын 97 орчим хувийг зөвхөн эрдэс бүтээгдэхүүн эзэлж байхад БНХАУ-ын тухайн барааны нийт импортод Монгол Улсын экспортын эзлэх хувь дөнгөж 2 хувийг эзэлж байгаа нь Хятадын тал манай экспортоос хамаарал султай байгааг харуулж байна. Эрдэс бүтээгдэхүүн нь БНХАУ-ын нийт импортод 24 орчим хувийг эзэлдэг аж.

Монгол Улсын экспортын харьцангуй давуу талд хийсэн шинжилгээнээс үзэхэд, харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүний дийлэнх хувийг олборлох үйлдвэрлэл, мал аж ахуйн гаралтай түүхий


эд зэрэг байгалийн баялагт түшиглэсэн бүтээгдэхүүн эзэлж байв⁵.

БНХАУ-ын импортын харьцангуй давуу талын индексээс харахад, БТКУС-ийн 97 бүлэг бараанаас 20 орчим нь импортын харьцангуй давуу талтай байгаа ба гол төлөв байгалийн баялаг, түүхий эд бүхий бүлгүүд байсан. Эндээс үзэхэд, БНХАУ түүхий эд импортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр ихээхэн амжилт олсон болох нь харагдаж байгаа юм.

Монгол Улсын экспортын харьцангуй давуу талтай бүтээгдэхүүн болох түүхий эд, байгалийн баялаг (Зураг 3) Хятадын импортын харьцангуй давуу талтай ерөнхийдөө давхцаж байгаагаас хоёр орны хоорондох худалдаанд түүхий эдийн худалдаа зонхилох болжээ.

Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй нийт барааны 90 орчим хувийг 2008 оноос хойш нүүрс, зэсийн концентраци, түүхий нефть, төмрийн хүдэр, цайр эзэлж байгаа бөгөөд 2010-2017 оны өөрчлөлтийг дараах (Зураг 4)-т харуулав.

Зураг 4. Хятад руу экспортолж буй гол нэрийн бүтээгдэхүүн (2010-2017 он, хувиар)



Эх сурвалж: Олон улсын худалдааны төвийн статистик

⁵ Отгонсайхан Н. (2014) Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдааны өнөөгийн байдал. ШУА-ийн олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл. – УБ 2014. – № 1. – 45-55-р тал

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

Цаашид БНХАУ-ын импортын харьцангуй давуу тал, Монгол Улсын экспортын харьцангуй давуу тал дээр үндэслэн худалдаа хийх нь манай дотоодын зах зээл дээр урт хугацаанд уул уурхайд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлд шаардлагатай стратегийн түүхий эд, мөн арьс шир боловсруулах, ээрмэл, сүлжмэлийн үйлдвэрийн түүхий эдийг худалдан авах өрсөлдөөнийг улам хүчтэй болгож болзошгүй байна. Тиймээс дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай юм.

Цаашид Замын-Үүдийн чөлөөт бүсийг ашиглан үйлдвэрлэл хөгжүүлэх боломжийг харахын тулд Монгол Улсын БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар хийгдэж буй экспорт, импортын өнөөгийн байдлыг судалж дараах хүснэгт (2)-д харуулав.

Хүснэгт 2. Монгол Улсын БНХАУ-тай хиллэдэг гол боомтуудаар хийгдэж буй экспорт, импортын хувийн жин (2010-2014)

Боомт	Экспорт,%					Импорт,%				
	2010	2011	2012	2013	2014	2010	2011	2012	2013	2014
Замын-Үүд	2.8	1.7	1.2	1.5	0.8	58.8	42.2	66.8	79.5	80.7
Бичигт	11.1	8.5	12.9	22.4	0.1	1.1	0.6	3.2	1.7	4.3
Ярант	0.1	0.0	0.8	0.0	0.1	2.0	1.7	2.1	3.5	2.4
Даян	0.00	0.00	0.02	0.00	0.01	0.01	0.01	0.00	0.02	0.00
Гашуунсухайт	42.6	46.4	48.9	38.0	17.7	26.2	15.2	8.1	3.9	2.2
Шивээхүрэн	38.0	36.5	29.0	17.1	6.7	5.1	7.0	3.6	1.1	0.4
Бургастай	2.2	4.0	6.8	10.4	3.6	0.5	1.4	1.4	0.9	1.4
Дорнод	3.3	2.8	0.4	1.3	17.3	3.1	3.1	3.4	3.6	3.9
Оюутолгой	-	0.0	0.0	9.2	53.8	3.3	28.8	11.5	5.8	4.7

Тайлбар: Монгол Улсын гаалийн статистик мэдээлэл дээр тулгуурлан тооцоолов.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Дорноговь аймгийн Замын-Үүд төмөр замын боомт нь 1956 онд нээгдсэн бөгөөд импортын өргөн хэрэглээний барааг энэ боомтоор авч байна. Тус боомтоор импортолсон барааны бүтэц (хүснэгт 3)-ээс үзэхэд, цахилгаан (HS 85) болон механик машин тоног төхөөрөмж (HS 84), тээврийн хэрэгсэл (HS 87) болон барилга барихад шаардлагатай төмөр (HS 72) болон ган хийц (HS 73), цемент (HS 25) голлох буюу 60 орчим хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Монгол Улс БНХАУ-аас Замын-Үүд боомтоор импортолсон барааны бүтэц (барааны бүлгээр, хувиар)

№	HS code	Барааны тодорхойлолт	Хувийн жин
1	84	Машин ба механик төхөөрөмж, тэдгээрийн эд анги	14.1%
2	72	Хар төмөрлөг (арматур)	12.7%
3	73	Төмөр буюу гангаар хийсэн эдлэл	11.1%
4	25	Шаварлаг эрдэс, шохой болон цемент	9.6%
5	87	Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	7.6%
6	39	Хуванцар болон хуванцар эдлэл	5.6%
7	85	Цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл болон тэдгээрийн эд анги	5.0%
8	27	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн; битумын эрдэс; эрдэс лав.	4.7%
9	44	Мод ба модон эдлэл (хаалга, цонх гэх мэт)	4.3%
10	68	Барилгын блок	3.7%
11	94	Тавилга; ор дэрний зөөлөн эдлэл, матрац, матрацны тулгуур, зөөлөвч ба тэдгээртэй төстэй гэр ахуйн чихмэл зөөлөн эдлэл	2.8%
12	69	Керамик эдлэл	2.1%

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

№	HS code	Барааны тодорхойлолт	Хувийн жин
13	90	Оптик, гэрэл зураг, кино зураг, хэмжүүр, хяналт, нарийвчлал, эмнэлэг буюу мэс заслын багаж ба аппарат; тэдгээрийн эд анги ба тоног хэрэглэл.	2.0%
14	07	Хүнсний ногоо, булцуут ба үндэс үрт хүнсний ургамал	1.7%
15	48	Цаас ба картон; цаасны зутан, цаас буюу картоноор хийсэн зүйлс.	1.4%
16	70	Шил ба шилэн эдлэл	1.4%
17	32	Идээлэгч буюу будагч бодисын ханд; таннинууд, тэдгээрийн уламжлал; нөсөө, будагч, өнгө оруулагч бусад бодисууд; найруулсан будаг, чий (лак); чигжээс, шаваас; бэх.	1.2%
18	40	Хаймар (каучук) ба хаймран эдлэл.	1.1%
		Бусад	7.9%

Тайлбар: Монгол Улсын гаалийн статистик мэдээлэл дээр тулгуурлан тооцоолов.

Харин тус боомтоор экспортолж буй барааны 70 гаруй хувийг малын гаралтай боловсруулаагүй арьс шир эзэлж байгаагаас харахад Замын-Үүд – Эрээний хил дамнасан чөлөөт бүсэд Монгол-Хятадын хамтарсан арьс, нэхийний үйлдвэрийн кластер байгуулах нэг боломж харагдаж байна. Ингэснээр нэмүү өртөг шингэсэн барааны экспорт нэмэгдэж, тээврийн зардал⁶, чөлөөт бүсэд үйлчлэх татварын тусгай хөнгөлөлт⁷ зэргээс дотоодын зах зээл дээр хувцас, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулж болохоос гадна гуравдагч

⁶ Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт богино хугацаанд тээвэрлэлт хийсэн тохиолдолд тээврийн зардал 30 хувиар буурна.


⁷ Зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

орны тухайлбал, ОХУ-ын зах зээлд худалдаалах боломжтой юм.

Монгол Улс нүүрсийг бараг 100 хувь БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд 2017 онд нийт 2256.7 сая ам.долларын 32990.9 мян. тн нүүрс экспортолсны 98 хувь буюу 2187.8 сая ам.долларын 32291.7 мян.тн нүүрсийг БНХАУ-д гаргажээ.

Монгол Улсын нүүрсний экспортод Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуунсухайт болон Гурван тэс сумын Шивээхүрэн боомтууд⁸ нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Гашуунсухайт боомтоор экспортолсон барааны 99, Шивээхүрэн боомтоор экспортолсон барааны 100 орчим хувь нүүрс байгаа бөгөөд дараах зураг (5)-т 2003-2017 оны нүүрсний экспортын динамикийг үзүүлэв.

Зураг 5. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй нүүрсний хэмжээ, үнийн дүн, БНХАУ-ын эзлэх хувийн жин




Эх сурвалж: Монгол Улсын гаалийн статистик

⁸ Засгийн газрын шийдвэрээр байнгын ажиллагаатай болгосон: 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Гашуунсухайт, 2009 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Шивээхүрэн. 2015 онд Даваа-Баасан гарагт 17-20 цаг, Бямба гарагт 08-20 цагийн хооронд нүүрсний тээвэр, “Оюутолгой” ХХК-ийн бараа, бүтээгдэхүүн, газрын тосны бүтээгдэхүүн экспортлох, импортлох хоёр талын аж ахуйн нэгжийн хүмүүс, бараа, бүтээгдэхүүн тоног төхөөрөмж, материал түүхий эд, тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, Даваа-Баасан гарагт 08.00-17.00 цагт бүх нийтэд үйлчлэх болсон.

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

Монгол Улс түүхий нефтийг 100 хувь БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд 2017 оны байдлаар 374.1 сая долларын 7.5 сая баррель (Зураг 6) түүхий газрын тос гаргажээ. Дорнод аймгийн Баянхошууны боомтоор түүхий газрын тосны 90 гаруй хувь нь гардаг. Харин Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомт нь 1992 онд нээгдсэн ба 2008 оноос олон улсын шинжтэй, байнгын статустай болсон. Уг боомт нь зүүн аймгуудад төдийгүй, Монгол Улсын далайд гарах хамгийн дөт, Замын-Үүдийн ачааллыг бууруулах чухал ач холбогдол бүхий боомт гэж үздэг. БНХАУ-д экспортолдог нийт барааны 20 гаруй хувь уг боомтоор гардаг ба үүний 98 гаруй хувь нь түүхий газрын тос, 1-2 хувь нь хүрэн нүүрс байдаг.

Зураг 6. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй түүхий газрын тос
(хэмжээ, үнийн дүнгээр)



Эх сурвалж: Монгол Улсын гаалийн статистик

Ховд аймгийн Ярантын боомтоор 40 гаруй нэр төрлийн бараа экспортолсноос үнийн дүнгийн 27.1 хувь нь чулуун нүүрс, 24.1 хувь нь цайрын хүдэр, баяжмал байсан. Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор төмрийн хүдэр баяжмал экспортолдог.

IV. БНХАУ-тай хил дамнасан чөлөөт бүс байгуулах боломж

Стратегийн түншлэлийн хүрээнд 2020 он гэхэд Монгол Улсаас БНХАУ-тай хийх худалдааг 10 тэрбум ам.долларт хүргэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хоёр талын худалдаан дахь хувийг нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжих зорилтыг хангахад хил дамнасан чөлөөт бүсийн үүрэг их юм.

Монгол Улсын хувьд БНХАУ-тай хил дамнасан чөлөөт бүс байгуулах хамгийн эхний боломжит хувилбар бол “Замын-Үүд” чөлөөт бүсийг түшиглэх явдал. Тус бүс нь манай улсын гадаад худалдаа, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулахуйц бүс нутаг.

“Замын-Үүд” чөлөөт бүс нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн цэс дотор нийслэл Улаанбаатар хотоос 680 км, Сайншанд хотоос 230 км, БНХАУ-ын Эрээн хотоос 5 км-ын зайтай 900 га талбайд оршдог байршлын давуу талтай.

Хил дамнасан чөлөөт бүсэд хамтын ажиллагаа, байгууллагын тогтолцоог зэрэг хангах дээд түвшний засаглал, эдийн засгийн маш таатай бодлого, санхүүгийн дэмжлэг байхаас гадна дэд бүтцийг бий болгосон байдаг. Тэгвэл “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийг 2007 онд санаачлан боловсруулсан ба 2011-2018 онд дулаан хангамж, усан хангамж-ариутгах татуургын байгууламж, цахилгаан хангамж, авто зам холбоо гэсэн үндсэн чиглэлээр төсөл амжилттай хэрэгжиж байгаа аж. Тухайлбал:

- ✓ “Замын-Үүд” чөлөөт бүс, Замын-Үүд сумыг дулаанаар хангах 90 мВт-ын хүчин чадалтай дулааны станц, дулаан дамжуулах төвийг чөлөөт бүсэд 5, Замын-Үүд суманд 7 ширхэгийг холбогдох шугам сүлжээний хамт барьж байгуулжээ.

- ✓ Цахилгаан хангамжийн хувьд Замын-Үүд сумын 110/10кВ-ийн дэд станцийг өргөтгөж “Замын-Үүд” чөлөөт бүсэд 2х16 мВт хүчин чадалтай дэд өртөө барьж, 10/04 кВ-ын 16 ширхэг хувиарлах байгууламжийг барьж ашиглалтанд өгөхөөр ажиллаж байгаа юм.
- ✓ Замын-Үүд сумын нийт 20 мянга гаруй иргэд болон “Замын-Үүд” чөлөөт бүсийг цэвэр усаар хангах 500м³ усны танк дөрвөн ширхэг, чөлөөт бүсэд байрлах 1600м³ цэвэр усны өргөтгөлийн станц, хоногт 3200 м³ хүчин чадалтай ус цэвэршүүлэх үйлдвэрийг холбогдох шугам сүлжээний хамт барьж байгуулсан.
- ✓ Чөлөөт бүсэд бохирын түрэлтэд станц 2 ширхэг, хоногт 3040 м³ хүчин чадалтай бохирын цэвэрлэх байгууламж, даралттай шугам 3 км, өөрийн урсгалын бохирын шугам 2 км, 13.6 км бохир усны шугам болон 9.8 км цэвэрлэгдсэн усны шугамтай хамт хийж гүйцэтгэжээ.
- ✓ Чөлөөт бүсэд эхний ээлжинд гол гудамж 5.4 км, хорооллын чанартай гол гудамж 6.9 км, чөлөөт бүсийг боомт хооронд холбосон 6 эгнээ бүхий 1.25 км, нийт 13.6 км авто замын ажлуудыг чанарын өндөр түвшинд хийжээ.
- ✓ “Замын-Үүд” чөлөөт бүс БНХАУ-аас 50 сая, Монголын Засгийн газрын 8.8 сая ам.долларын санхүүжилтийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2015-2017 онд 4 удаагийн сонгон шалгаруулалтаар 24 аж ахуйн нэгжийн 27 төсөлд 58.57 га газар олгожээ. Талбайг үйлдвэрлэлийн, худалдааны, амралт зугаалгын, агуулахын, нөөцийн бүс гэж төлөвлөсөн бөгөөд үйлдвэрлэлийн бүс зонхилох хувийг эзэлнэ.

Замын-Үүдийн чөлөөт бүс нь энэ төрлийн чөлөөт бүс байгуулах хамгийн таатай урьдчилсан нөхцөлийг хангаж байгаа учраас Монгол Улсын талаас уг бүсэд үйл ажиллагаа явуулахаар сонгон шалгаруулалтаар газар авсан аж ахуйн нэгжүүдийг дэмжин

бизнесийг нь эхлүүлэх нь зөв.

Монгол Улсын хувьд Чөлөөт бүс байгуулах туршлага байхгүй, харин БНХАУ 30 гаруй жилийн туршлагатай. Энэ боломжийг ашиглан Замын-Үүд, Эрээний хил дамнасан чөлөөт бүсийг байгуулж, Монгол Улсын харьцангуй давуу талтай бүтээгдэхүүн болох малын болон байгалийн гаралтай түүхий эдэд тулгуурласан үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт татах замаар эдгээрийг тойрсон кластерийг хөгжүүлэхэд анхаарна. Ялангуяа олон улсын дүрэм, журамд нийцсэн гадаадын хөрөнгө оруулалтын тогтвортой эрхзүйн орчныг бий болгож, үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй болгох, чөлөөт бүсэд хориглох, хязгаарлах үйлдвэрлэл, үйлчилгээг нарийн тодорхойлж, чанд мөрдүүлдэг жишиг тогтоох шаардлагатай юм.

Түүнчлэн Монгол Улсын хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний экспортын нэр төрлийг нэмэгдүүлэх, БНХАУ-ын хэрэглэгчийг органик хүнсээр хангахад тухайлбал, рапс, хивэг, хөх тарианы гурил экспортлох аж ахуйн нэгжүүдэд БНХАУ-ын талаас эрсдэлийн үнэлгээ хийх, адууны мах болон боловсруулсан махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох аж ахуйн нэгжүүдийг хянан магадлах, мөн дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж болон адууны мах боловсруулах аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийхэд хамтран ажиллах гэх мэт ажлуудыг хийх хэрэгтэй.

Хил дамнасан чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Монгол Улсад тарифын болон тарифын бус хөнгөлөлт үзүүлж буй АНУ, ЕХ, Япон болон ОХУ-ын зах зээлд гарах боломжийг эрэлхийлэх. Эдгээр орны зах зээлд гарахад Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр маш чухал үүрэгтэй бөгөөд эхний ээлжинд хэрэгжүүлэхээр болсон 3 төсөл дээр Монгол Улс хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

Азийн авто замын сүлжээний АН-3 буюу Улаан-Үд–Алтанбулаг–Улаанбаатар–Замын-Үүд–Эрээн чиглэлийн хурдны авто замын төслийг БНХАУ-тай яаралтай хамтран хэрэгжүүлэх.

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс
байгуулах урьдчилсан нөхцөл, боломж

Мөн манай хөрш орнууд худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс зэрэг эдийн засгийн бүтэц бий болгох замаар хил орчмын нутаг дэвсгэрээ суурьшлын орон зай болгох, улсынхаа үндэсний аюулгүй байдлыг хангахад нилээд анхаарч байна. Энэ туршлагаар Монгол Улсын баруун бүсэд хил дамнасан чөлөөт бүсийг байгуулах боломж байна гэж үзэж байна.

Баруун бүс нь ОХУ, БНХАУ-тай хиллэхээс гадна Казакстан улстай хамгийн ойр байрладаг, Дундад Ази, Европт хамгийн ойрхон орших Монголын баруун хязгаарын хилийн цэгийн хувьд байршлын давуу талтай.

Түүнчлэн баруун бүсэд Торгоны болон Талын зам төслүүдийг уялдуулж, эдгээр төслийн хүрээнд Монгол Улс, ОХУ, БНХАУ гурван улсын “хил дамнасан чөлөөт бүс”-ийг байгуулах боломжийг судлах шаардлагатай. Монгол Улс ойрын хугацаанд Азийн өндөр хурдны автозамын сүлжээнд 3 чиглэлээр холбогдохоор төлөвлөж байгаа бөгөөд АН4 (Улаанбайшинт – Өлгий – Ховд – Ярант) чиглэл нь баруун бүсийг дайран өнгөрч байгаа. Энэ зам нь Монгол Улсын хойгуур өнгөрөх ТРАНССИБИРЬ магистрал, урдуур өнгөрөх ТРАСЕКА олон улсын магистрал (өрнөөс дорно хүрэх) хоёрыг холбож байгаагаараа чухал ач холбогдолтой.

Түүнчлэн ОХУ болон БНХАУ-ыг холбох хамгийн дөт зам бол Баруун бүсийн Улаанбайшинтаас Даянгийн боомт хүртэлх 212 км зам. Тэгэхээр энэ бүсийг ашиглан ОХУ нь Шинжаан Уйгарын, БНХАУ нь Европын зах зээлд гарах, Монгол Улсын хувьд Төв Азийн улс орнууд руу гарах чухал гарц бий болно.

Үүнээс гадна ойрын ирээдүйд ОХУ, БНХАУ-ыг Монголын нутгаар холбосон төмөр зам тавигдах нөхцөл бүрдэж байгаа нь дээрх олон улсын тээврийн коридоруудыг төмөр замаар холбох боломжийг үгүйсгэхгүй.

АН-4 болон Даян – Улаанбайшинтын зам ашиглалтанд орсноор Монголын баруун бүсээр дамжих худалдааны асар их урсгал бий болно. Нөгөөтэйгүүр далайн тээвэрлэлтийн хугацааг 2-3 дахин

багасгаж, зардлыг бууруулах боломжтой гэсэн тооцоо судалгаа байдаг.

Хил залгаа гурван улсын хүн амын 60 орчим хувь нь казак хэлээр ярьдаг. Монгол Улсын Баруун таван аймаг БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймаг, ОХУ-ын Алтайн хязгаарын хотууд: Барнаул, Биск, Новосибирск болон Алтайн БН улс, Тува, Хакастай худалдаа, эдийн засгийн уламжлалт харилцаатай явж ирсэн нь энэ бүс нутагт Чөлөөт бүс байгуулах давуу тал болж өгнө.

Нөгөө талаас, БНХАУ-ын баруун хойд муж /тухайлбал Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орон, 30 сая хүн амтай/ сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа учраас манай улсын баруун бүсээр дамжин ОХУ-аас ашигт малтмал, түүхий эд материал, мод авч оронд нь өргөн хэрэгцээний төрөл бүрийн бараа нийлүүлэх сонирхолтой. Харин ОХУ-ын Алтайн хязгаарын БН улс Хятадын хямд бараа, бүтээгдэхүүнийг аль болох дөт замаар авах эрмэлзэлтэй.

Монгол Улс, ОХУ, БНХАУ, Казахстаны хосгүй үзэсгэлэнт байгаль, Алтайн уулсыг тойрсон олон улсын аялал жуулчлалын цагираг дээр байрладаг. Иймд жуулчдад зориулсан олон төрлийн үзвэр /бүргэдийн, олон үндэстэн ястны түүх, соёл, археологи, ёс заншлын г.м./ үйлчилгээ хөгжүүлэх давуу талтай.

Баруун бүс нутагт аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх түүхий эдийн нөөц харьцангуй их бий гэдгийг бүсийн хөгжлийн хөтөлбөрт тодорхойлсон. Тухайлбал, экспортлох боломжтой улсын нийт махны 23.3 хувь тус бүсэд ногдож байгаа бөгөөд энэхүү үзүүлэлтээр Хангайн бүсийн (37.5 хувь) дараа ордог. Иймд махны чиглэлийн жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулж хөгжүүлэх замаар мах, махан бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Мөн хонь, ямааны ноос, ноолуур бэлтгэлийн чадавхийн хувьд баруун бүс нь улсад тэргүүлдэг бөгөөд улсын нийт хонины ноос бэлтгэлийн 30.4 хувийг, ямааны ноолуурын 33.8 хувийг, тэмээний ноосны 27.3 хувийг, адуу, үхрийн хөөврийн 18.4 хувийг тус тус бэлтгэх чадавхитай гэсэн тооцоо байна. Цагааннуур, Холбоо, Ачит зэрэг нууруудад загасны аж ахуй эрхэлж загасны түрс, нухаш зэргийг экспортлох боломжтой.

Баруун бүсэд 15 төрлийн ашигт малтмалын 294 орд, илэрц байгаагаас 39 нь 8 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байгаа аж. Баруун бүсэд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд юуны өмнө алт, алт-холимог металл, мөнгө, фосфорит, мөнгө-холимог металл, гянтболд, газрын ховор элементийн орд газруудыг ашиглах, энэ чиглэлээр хийх хайгуулын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа аж.

Томоохон ордуудыг ашиглахад үндсэндээ дэд бүтцийн асуудал хүлээгдэж байна гэж хэлж болно. Иймээс Торгоны болон Талын зам төслүүдийг уялдуулж, эдгээр төслийн хүрээнд гурван улсын “хил дамнасан чөлөөт бүс”-ийг байгуулах нь хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажлуудыг богино хугацаанд хурдан гүйцэтгэх, гурван улсын хувьд харилцан ашигтай байх нэг нөхцөл байж болох юм.

Улс орнууд энэ хэлбэрийн чөлөөт бүсийг байгуулахдаа хил дамнасан тусгай нутгийг сонгож, хилийн бүс нутгуудын хоорондын харилцааг сайжруулах, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар бүс нутгийн интеграци руу шилжих макро түвшний зорилтуудыг ч тавьдаг ажээ.

Монгол Улс анхны чөлөөт худалдааны хэлэлцээрийг Япон Улстай байгуулсан нь Азийн бүс нутгийн интеграцид орох эхний алхам болсон. Харин хөрш БНХАУ-тай хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах нь илүү үр дүнтэй хувилбар байж болох юм.

Энэхүү чөлөөт бүсийг байгуулахдаа бусад орнуудын туршлагыг судлах зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал, БНХАУ, Казахстаны хилийн бүст байгуулагдсан Хоргосын чөлөөт бүс нь бидний судлах ёстой хамгийн ойрын жишээ. Энэ бүс нь БНХАУ-ын Төв Ази, Өмнөд Ази, цаашлаад Европ руу гарах гол гарцуудын нэг гэж тооцогддог, олон улсын зэрэглэлийн эдийн засгийн нээлттэй бүс бөгөөд боловсруулах үйлдвэрийг голлон хөгжүүлэхээр төлөвлөжээ.

**Precondition and possibilities for
establishing cross border free zone between Mongolia-China**

N.Otgonsaikhan.

Business School, National University of Mongolia,

E-mail: otgonsaikhan@num.edu.mn

Abstract. *As for Mongolia, which is a landlocked and has vast land, establishment of free-trade and economic zone by extending border points with neighboring countries can be a main solution to keep border security, to promote regional development, to develop infrastructure of transportation and to expand trades. Recently, special focus on establishing cross-border free zone between Mongolia and China has been made and several negotiations in this field have been held by 2 countries' governments. Therefore, the paper work aims to study pre-conditions and possibilities for establishing cross-border free zone between Mongolia and China. This thesis consists of following main 4 parts: 1) negotiations for cross-border free zone between Mongolia and China, 2) Cross-border free zone and Mongolian current situation, 3) Mongolia-China bilateral trade, 4) The possibility of establishing a cross-border free trade zone with China.*

Key words. *Foreign trade, export, import, cross-border free zone, strategic partnership*

Ашигласан материал:

1. “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө (2009)
2. “Чөлөөт бүсийн эрхзүйн зохицуулалт, онцлог, түүхэн хөгжлийн талаарх гадаадын зарим орны туршлага” УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн судалгаа (2013)
3. Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын хавсралт (2005), <http://www.legalinfo.mn/law/details/2896>
4. Болд Л. (2014) Чөлөөт бүс байгуулах нь үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын чухал үндэс суурь юм. <http://politics.news.mn/content/174698.shtml>
5. Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр (2013)
6. Монгол Улсын “Хилийн боомтын тухай” хууль (2013)
7. Отгонсайхан Н. (2014) Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдааны өнөөгийн байдал. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл. –УБ 2014. – № 1. – 45-55-р тал
8. Отгонсайхан Н., Нарандалай Д. (2015). Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах чиглэл. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл. –УБ 2014. – № 4. – 146-162-р тал
9. Бизьяа Р. Хилийн боомт бол стратегийн чухал объект. “Зууны мэдээ” сонин 2013 оны 2 дугаар сарын 6

10. <http://www.parliament.mn>
11. <http://mi.gov.mn>
12. <http://mfa.gov.mn>
13. <http://ecustoms.mn>
14. www.cabinet.gov.mn